



**Харилцаа холбооны зохицуулах хорооны  
2023 оны ээлжит бус 02 дугаар хуралдааны  
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 02 дугаар хуралдааныг 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулав.

Энэхүү зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 02 дугаар хуралдаанаар ХХЗХ-ноос 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийн төлбөр тогтоосон тухай танилцуулга; Тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сунгах, сэргээх, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн хорооны хуралдааны 6 тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7-р зүйлийн 7.4.5-д “Энэ хуулийн 6.1.6-д зааснаас бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулах”, Харилцаа холбооны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1.4-т зааснаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны А/42 тоот тушаалын хавсралтаар баталсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ын 2.7-д “Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгосон тохиолдолд сонгон шалгаруулалтын эрхийн төлбөрийг Харилцаа холбооны зохицуулах хороо тухай бүр тогтооно” гэж заасан. Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.11-т зааснаар энэ хуулийн 6.1.4-д заасан журмын дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлсний хувь хэмжээг тогтооно гэсний дагуу 2021 оны 26 тоот тогтоолоор “Сонгон шалгаруулалтын эрхийн төлбөр” тогтоох тухай тогтоолыг батлан мөрдөж байна. Тус хорооноос 2021, 2022 онуудад зохион байгуулсан Сонгон шалгаруулалтаар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход энэхүү тогтоолын дагуу эрхийн төлбөр авч байгаа болно. Тус хуралдаанаас “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”-ын 2.7-д “Тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгосон тохиолдолд сонгон шалгаруулалтын эрхийн төлбөрийг Харилцаа холбооны зохицуулах хороо тухай бүр тогтооно” гэж заасны дагуу эрхийн төлбөрийг тус хороо тухай бүр тогтоох боломжтой боловч 2023 онд нээлттэй сонгон шалгаруулалтаар олгох өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийн төлбөрийн хэмжээг 2021 оны 26 тоот тогтоолд зааснаар мөрдөн ажиллах нь зүйтэйг гэж тогтов.

Зохицуулах хорооны 2023 оны ээлжит бус 02 дугаар хуралдаанаар тусгай зөвшөөрлийн тухай (ТЗ шинээр олгох, сунгах, сэргээх, нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 5 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 6 тогтоолыг хавсралтын хамт батлав. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12

дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 10<sup>1</sup> дүгээр зүйлийн 10<sup>1.1</sup> дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 41 тоот тогтоолын хавсралтаар 7 хуулийн этгээдэд 7 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 42 тоот тогтоолын хавсралтаар 8 хуулийн этгээдийн 8 тусгай зөвшөөрлийг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 43 тоот тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 44 тоот тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдийн 5 тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 45 тоот тогтоолын хавсралтаар 5 хуулийн этгээдийн 5 тусгай зөвшөөрлийг сэргээсэн;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1.1.8</sup> дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 46 тоот тогтоолын хавсралтаар 15 хуулийн этгээдийн 15 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон тус тус шийдвэрлэв.

Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг <http://www.crc.gov.mn/main.php?cid=1&do=70&did=0> үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо  
2023-05-16